



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Чулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/059/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 99197346

Цахим хаяг: Info@shinjenmagadlakhui-audit.mn
<mailto:Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com%20>

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 76
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЧУЛУУТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ЛОЖИДПИЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2,892,790.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 2,707,805,3 мянган төгрөгийг зарцуулж 184,985.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 үндсэн зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	263,743,233.66	266,038,888.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	205,026,883.16	184,985,315.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	205,026,883.16	184,985,315.51
3121	Төгрөг	205,026,883.16	184,985,315.51
31211	Төрийн сангийн харилцах	205,026,883.16	184,985,315.51
33	АВЛАГА	-	30,564,530.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	30,564,530.47
35	БАРАА МАТЕРИАЛ	58,716,350.50	50,489,042.96
351	Түүхий эд материал	695,000.00	695,000.00
35130	Эм боох материал	695,000.00	695,000.00
354	Хангамжийн материал	58,021,350.50	49,794,042.96
35410	Бичиг хэргийн материал	4,517,836.00	3,625,836.00
35420	Аж ахуйн материал	50,969,712.00	40,107,682.96
35440	Түлш, шатах тослох материал	-	2,744,000.00
35460	Хүнсний материал	2,533,802.50	3,316,524.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,605,997,662.22	4,352,055,373.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,605,997,662.22	4,352,055,373.34
392	Биет хөрөнгө	4,533,195,995.70	4,280,653,706.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,405,683,458.00	4,405,683,458.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(253,167,199.92)	(450,177,511.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,120,000.00)	(18,480,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	340,904,479.76	333,093,369.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(127,687,028.94)	(172,317,181.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	204,152,756.80	226,535,937.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(90,096,940.69)	(110,937,856.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,666,666.72)	(10,000,000.00)
39217	Ном	31,593,137.41	33,653,491.41
393	Биет бус хөрөнгө	72,801,666.52	71,401,666.48
39301	Програм хангамж	7,000,000.00	7,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,098,333.48)	(6,498,333.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	70,900,000.00	70,900,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,869,740,895.88	4,618,094,262.28
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,019,991.00	270,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,019,991.00	270,000.00
413	Өглөг	17,019,991.00	270,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	17,019,991.00	270,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,852,720,904.88	4,617,824,262.28
51	Засгийн газрын хувь оролцоо	4,852,720,904.88	4,617,824,262.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	506,696,493.87	506,696,493.87
51101	Өмч: - төрийн	506,696,493.87	506,696,493.87
512	Хуримтлагдсан үр дүн	3,777,478,037.30	3,542,581,394.70
51210	Өмнөх үеийн үр дүн	3,777,478,037.30	3,777,478,037.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(234,896,642.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	568,546,373.71	568,546,373.71
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,869,740,895.88	4,618,094,262.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Архангай аймгийн Чулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,809,261,009.00	3,117,046,671.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	144,687,809.00	21,889,171.40
120	Нийтлэг татварын бус орлого	144,687,809.00	21,889,171.40
120009	Бусад орлого	10,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	133,536,686.20	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,151,123.00	21,550,756.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,664,573,200.00	3,095,157,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,581,090,700.00	2,892,790,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,581,090,700.00	2,892,790,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	60,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,482,500.00	142,366,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,482,500.00	142,366,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,861,618,212.72	3,351,943,314.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,861,618,212.72	3,351,943,314.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,751,882,735.32	3,223,234,465.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,843,308,852.89	2,216,126,124.53
210101	Үндсэн цалин	1,126,501,108.89	1,298,600,926.53
210102	Нэмэгдэл	535,541,605.00	685,287,262.00
210104	Урамшуулал	181,266,139.00	232,237,936.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,546,910.45	263,381,032.65
210201	Тэтгэврийн даатгал	159,199,971.60	179,851,305.88
210202	Тэтгэмжийн даатгал	18,260,719.06	21,144,375.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,759,290.83	11,865,025.04
210204	Ажилгүйдлийн даатгал	9,280,102.23	10,470,811.10
210205	Эрүүл мэндийн даатгал	34,046,826.73	40,049,515.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,352,763.00	118,638,409.00
210301	Гэрэл, цахилгаан	25,966,123.00	34,812,837.00
210302	Түлш, халаалт	49,706,640.00	78,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,680,000.00	5,425,572.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,017,302.27	-
210408	Бараа материал акталсны зардал	68,017,302.27	-
2105	Нормативт зардал	78,704,622.50	114,639,869.50
210502	Хоол, хүнс	78,704,622.50	114,639,869.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,535,500.00	3,150,000.00
210604	Урсгал засвар	1,535,500.00	3,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,611,500.00	28,721,819.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,117,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	41,493,600.00	28,721,819.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	404,805,284.21	478,577,209.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,737,811.00	151,653,037.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,268,900.00	13,833,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	300,798,573.21	313,091,172.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,735,477.40	128,708,849.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	109,735,477.40	128,708,849.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	78,934,177.40	109,823,519.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,801,300.00	18,885,330.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(52,357,203.72)	(234,896,642.60)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-

IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(52,357,203.72)	(234,896,642.60)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,674,573,200.00	3,095,157,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	10,000,000.00	-
120009	Бусад орлого	10,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,664,573,200.00	3,095,157,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,581,090,700.00	2,892,790,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,581,090,700.00	2,892,790,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	60,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,482,500.00	142,366,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,482,500.00	142,366,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,495,260,214.34	3,077,600,940.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,495,260,214.34	3,077,600,940.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,389,768,039.34	2,945,637,390.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,843,308,852.89	2,244,592,285.00
210101	Үндсэн цалин	1,126,501,108.89	1,327,067,087.00
210102	Нэмэгдэл	535,541,605.00	685,287,262.00
210104	Урамшуулал	181,266,139.00	232,237,936.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,546,910.45	263,381,032.65
210201	Тэтгэврийн даатгал	159,199,971.60	179,851,305.88
210202	Тэтгэмжийн даатгал	18,260,719.06	21,144,375.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,759,290.83	11,865,025.04
210204	Ажилгүйдлийн даатгал	9,280,102.23	10,470,811.10
210205	Эрүүл мэндийн даатгал	34,046,826.73	40,049,515.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,982,500.00	138,366,900.00
210301	Гэрэл, цахилгаан	25,966,123.00	34,812,837.00
210302	Түлш, халаалт	54,336,377.00	98,128,491.00
210303	Цэвэр, бохир ус	1,680,000.00	5,425,572.00
2105	Нормативт зардал	80,087,565.00	114,731,900.00
210502	Хоол, хүнс	80,087,565.00	114,731,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,359,500.00	35,546,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,117,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,241,600.00	35,546,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,982,711.00	145,018,473.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,943,111.00	131,930,973.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,039,600.00	13,087,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,492,175.00	131,963,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,492,175.00	131,963,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,690,875.00	110,979,850.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,801,300.00	20,983,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	179,312,985.66	17,556,559.35
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	38,220,250.00	37,598,127.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,220,250.00	37,598,127.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,220,250.00	37,598,127.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,220,250.00	37,598,127.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(38,220,250.00)	(37,598,127.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	141,092,735.66	(20,041,567.65)
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		205,026,883.16
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205,026,883.16	184,985,315.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	3,777,538,037.30	4,852,780,904.88
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	3,777,538,037.30	4,852,780,904.88
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	3,777,538,037.30	4,852,780,904.88
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(234,896,642.60)	(234,896,642.60)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	3,542,641,394.70	4,617,884,262.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	3,088,786,300.00	3,095,157,500.00	-6,371,200.00	100.21
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,946,419,400.00	2,952,790,600.00	-6,371,200.00	100.22
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,946,419,400.00	2,892,790,600.00	53,628,800.00	98.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		60,000,000.00	-60,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		60,000,000.00	-60,000,000.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	142,366,900.00	142,366,900.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	142,366,900.00	142,366,900.00		100

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	263,115,200.00		263,115,200.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000,000.00		60,000,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	203,115,200.00		203,115,200.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,351,901,500.00	3,095,157,500.00	256,744,000.00	92.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,351,901,500.00	3,115,199,067.65	236,702,432.35	92.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,213,695,800.00	2,983,235,517.65	230,460,282.35	92.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,424,420,400.00	2,244,592,285.00	179,828,115.00	92.58
210101	Үндсэн цалин	1,447,731,700.00	1,327,067,087.00	120,664,613.00	91.67
210102	Нэмэгдэл	886,089,500.00	685,287,262.00	200,802,238.00	77.34
210104	Урамшуулал	90,599,200.00	232,237,936.00	141,638,736.00	256.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,179,300.00	263,381,032.65	39,798,267.35	86.87
210201	Тэтгэврийн даатгал	206,161,900.00	179,851,305.88	26,310,594.12	87.24
210202	Тэтгэмжийн даатгал	24,254,300.00	21,144,375.46	3,109,924.54	87.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,127,200.00	11,865,025.04	262,174.96	97.84
210204	Ажилгүйдлийн даатгал	12,127,200.00	10,470,811.10	1,656,388.90	86.34
210205	Эрүүл мэндийн даатгал	48,508,700.00	40,049,515.17	8,459,184.83	82.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,366,900.00	138,366,900.00		100
210301	Гэрэл, цахилгаан	37,182,500.00	34,812,837.00	2,369,663.00	93.63
210302	Түлш, халаалт	97,144,400.00	98,128,491.00	-984,091.00	101.01
210303	Цэвэр, бохир ус	4,040,000.00	5,425,572.00	-1,385,572.00	134.3
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	114,731,900.00	114,731,900.00		100
210502	Хоол, хүнс	114,731,900.00	114,731,900.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,000,000.00		100
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00		100
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,269,100.00	35,546,800.00	722,300.00	98.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,269,100.00	35,546,800.00	722,300.00	98.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,728,200.00	182,616,600.00	10,111,600.00	94.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	179,640,700.00	169,529,100.00	10,111,600.00	94.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,087,500.00	13,087,500.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,205,700.00	131,963,550.00	6,242,150.00	95.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,205,700.00	131,963,550.00	6,242,150.00	95.48

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	117,222,000.00	110,979,850.00	6,242,150.00	94.67
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,983,700.00	20,983,700.00		100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,351,901,500.00	3,115,199,067.65	236,702,432.35	92.94
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		205,026,883.16	205,026,883.16	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		184,985,315.51	184,985,315.51	-
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	75	75		100
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	45	45		100
8	Үйлчлэх ажилтан	28	28		100
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	732	732		100

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, залруулаагүй 20,000.0 мянган төгрөгийн зөрчил² илэрч 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 20,000.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 37,709.36 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 20,000,000 төгрөгийн бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цахим худалдан авалттай холбоотой	1	20,000.0			1	20,000.0							
Дүн	1	20,000.0			1	20,000.0	1	-					

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0	0	0	1	0
Дүн	1	0	0	0	1	0